



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1988 оны 11 сарын 21 өдөр

дугаар 291

Улаанбаатар хот

Зарим сургууль цэцэрлэгийг татан буулгах, өргөтгөх, шинээр нээн ажиллуулах тухай

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I. Хотын ардын боловсролын удирдах газрын дарга /С.Батмагнай/-т ДААЛГАХ нь:

а/Октябрийн районы X бичил хороололд ашиглалтад оруулсан 280 ортой цэцэрлэг-яслийн комбинатыг I20 гэсэн дугаар өгч II дүгээр сарын 5-наас, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн I987 оны 33 дугаар протоколыг үндэслэн БНМАУ-ын Хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн туслах аж ахуйн бага сургуулийг энэ хичээлийн жилээс эхлэн улсын төсвөөр ажиллах 8 жилийн дунд сургууль болгон 59 гэсэн дугаар өгч тус тус ажиллуулах.

б/"Сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйнуудыг бүрэн дунд сургууль, техник мэргэжлийн сургуулийн салбар ангитай болгох тухай "МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн I983 оны I7 дугаар тогтоол, Улаанбаатар хотын I988 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу I988-I989 оны хичээлийн жилээс эхлэн Гачууртын хорооны 8 жилийн дунд сургууль, Туул хорооны 8 жилийн 26 дугаар дунд сургууль, Сүхбаатар районы 8 жилийн 50 дугаар дунд сургуулийг I0 жилийн дунд сургууль болгон ажиллуулах.

в/Найрамцлын районы ОСГ-ны I5 дугаар хорооны зарим айл өрхүүд XIII хороололд барих барилгын талбайд орж нүүснээс суралцах хүүхдийн тоо цөөрснийг харгалзан тус районы 59 дүгээр бага сургуулийг татан буулгаж арван жилийн 2I дүгээр дунд сургуультай нэгтгэн, 59 дүгээр бага сургуульд ашиглаж байсан 24III төгрөгийн үндсэн хөрөнгийг мөн районы залуу техникчдийн салбар станцад шилжүүлэх.

2. Улсын барилгын шалган байцаах газар, улсын ариун цэвэр халдвар судлалын байцаан шалгах газруудын гаргасан акт дүгнэлтийг үндэслэн Ажилчны районы ОСГ-ны 8 дугаар хорооны дэвсгэрт ажиллаж байсан 33 дугаар цэцэрлэгийн 66000 төгрөгийн үнэтэй барилгыг данснаас хасах.

3. Шинээр ашиглалтад орсон ясли цэцэрлэгийн 120 дугаар комбинат, Хөнгөн үйлдвэрийн яамны нэгдсэн туслах аж ахуйн дэргэдэх 8 жилийн 59 дүгээр дунд сургууль, Сүхбаатар районы 50, Гачуурт, Туул хорооны арван жилийн дунд сургуулиудын орон тоо, төсвийг норм, нормативын дагуу баталж өгөхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

4. Дээрхи цэцэрлэг ясли комбинат, арван жилийн дунд сургуулиудад хэрэглэгдэх тэмдэг тамгыг зохих журмын дагуу холбогдох байгууллагуудаар хийлгэж хэрэглүүлэхийг Хотын ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/-д зөвшөөрсүгэй.



УЛААНБААТАР ХОТЫН АНХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА

Д.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АНХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.АЛГИА